



ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2022 – 11 САР | ДУГААР 48

ГАРЧИГ

1–3	Бодлогын нийтлэл
4–5	Зохицуулалтын мэдээ
6–8	Байр суурь
9	Ногоон санхүүгийн байдлын тайлан
10–11	Дэлхийн финтекийн хөгжлийн чиг хандлага
12–17	Даатгалын эрсдэл шилжүүлэх уламжлалт бус санхүүгийн хэрэгсэл, түүний зохицуулалт
18–21	Санхүүгийн боловсрол
22	Санхүүгийн тооцоололд суралцъя хичээл №9
23–24	Компанийн засаглал
25–26	Олон улсын зах зээлийн мэдээ
27	Олон улсын хөрөнгийн зах индекс

АРИЛЖААНЫ БАНКНУУДЫН ХУВЬЦАА ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ТОМООХОН ӨӨРЧЛӨЛТ ШИНЭЧЛЭЛИЙГ БИЙ БОЛГОНО



Арилжааны банкнууд олон нийтийн буюу хувьцаат компани болох асуудал сүүлийн 2 жилийн хугацаанд нэлээд яригдаж байна. Одоогийн байдлаар арилжааны банкнууд хувьцаат компани болох ажил ямар шатандаа явагдаж байгаа талаар товчхон мэдээлэл өгөөч?

Улсын Их Хурал /УИХ/-аас 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг тус тус баталснаар системийн нөлөө бүхий арилжааны банкнууд 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор санхүүгийн зах зээлд хувьцаа /IPO/ гаргаж нээлттэй хувьцаат компани болно.

Харин бусад банкнуудын хувьд хувьцаагаа олон нийтэд санал болгон нээлттэй хувьцаат компани болох эсхүл хаалттай хувьцаат компани хэвээр байх сонголтыг нээлттэй үлдээсэн.

УИХ-аас 2010 онд баталсан Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулга, тодорхой хугацаануудад оруулсан нэмэлт өөрчлөлтөөс харахад арилжааны банкнуудын засаглал, тайлагналын ил тод байдлыг бэхжүүлэх, эрсдэл даах чадварыг дээшлүүлж, хувьцаа эзэмшигчид болон охин, хараат компаниудын хоорондох сонирхлын зөрчлөөс сэргийлж, хязгаарлах, Монголбанкнаас тавих хяналтыг олон улсын жишиг, эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын тогтолцоонд шилжүүлэхэд чиглэсэн.

Үргэлжлэл 6-р нүүрт



ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

ЗАХ ЗЭЭЛИЙН ГАЖУУДАЛ

Дам нөлөө ихтэй, хэрэглээг нь хязгаарлаж үл болох нөхцөлд зах зээл бараа, үйлчилгээг хуваарилж чаддаггүй. Зах зээлийн механизм дангаараа эдийн засгийн бүх үүргийг гүйцэтгэж чаддаггүй бөгөөд төрийн бодлого шаардлагатай болдог. Зах зээлийн гажуудал нь төр зах зээлд оролцох ганц шалтгаан болдог.



MARKET FAILURE

Inability of the market to allocate goods and services effectively and efficiently, because of substantial externalities and because the exclusion principle cannot be applied. The market mechanism alone cannot perform all economic functions; public policy is needed 'to guide, correct, and supplement it in certain respects'. Market failure is one way in which government intervention can be justified.

*Эх сурвалж:
Засаглалын үзэл баримтлал, нэр
томьёоны тайлбар толь бичиг*



БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС ОЛГОХ ФИНТЕК ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨР, ОРЛОГЫН ХАРЬЦАА

Санхүүгийн зах зээл дээрх зээлийн бүтээгдэхүүний өр орлогын хязгаарлалтыг Монголбанкны ерөнхийлөгчийн 2018 оны А-176 дугаар тушаалаар банкнаас олгох иргэдийн хэрэглээний зээлд 70 хувь, 2019 оны А-83 дугаар тушаалаар 60 хувиас хэтрүүлэхгүй байхаар тус тус тогтоож байсан. Эдийн засгийн агуулга нь иргэдийг өрийн дарамтад оруулахаас сэргийлэх, мөн иргэдийн зээл рүү чиглэсэн зээлийн эх үүсвэрийг бизнесийн зээл рүү чиглүүлэх бөгөөд ингэснээр ажлын байр нэмэгдэж, иргэд өрөөр биш ажил эрхэлсэн орлогын өсөлтөөрөө хэрэглээгээ нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх алсын зорилготой байсан. Өрөөр өнөөдрийн хэрэглээгээ санхүүжүүлэх үйл явц даамжирвал ирээдүйн орлогоосоо өрөө төлөх тул ирээдүйн хэрэглээнд нь сөрөг нөлөөтэй байдаг.


Олон улсын туршлагаас харахад хэрэглээний зээлд өр, орлогын хязгаарлалтыг тавин хэрэгжүүлж буй нэг шалтгаан нь өрхийн орлогын дарамтыг бууруулах явдал бөгөөд ингэснээр зээлийн эргэн төлөлт сайжирч, санхүүгийн зах зээл дэх чанаргүй зээлийн хувь хэмжээ буурах нөлөөтэй байдаг.

Банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/-ын салбарт технологид суурилсан зээлийн үйлчилгээ буюу финтек зээлийн бүтээгдэхүүн нь 2017 оноос нэвтэрч эхэлсэн бөгөөд хөгжлийн хурдцыг даган ББСБ-ын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12-оор нэмэгдэж, 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 36 ББСБ энэ төрлийн үйл ажиллагааг зах зээлд хүргэж байна.

Финтек зээлийн бүтээгдэхүүний уламжлалт зээлээс ялгарах онцлог нь иргэдэд техник технологийг ашиглаж барьцаа хөрөнгө шаардахгүй, богино хугацаатай, бага хэмжээний зээлийг тусгай зөвшөөрөлтэй, төрийн зохицуулалттай, мэргэжлийн ББСБ-аас хялбар, түргэн шуурхай цаг, зардал хэмнэн нөхцөл багатайгаар авах боломжийг олгодог.

Финтек зээлийн бүтээгдэхүүн гаргаж буй 36 ББСБ-ын 5 нь зөвхөн аппликэйшн ашиглан зээл олгож байгаа бол 31 ББСБ нь уламжлалт болон финтекийг хослуулан зээл болон бусад төрлийн санхүүгийн үйлчилгээг санал болгож байна.

Хүснэгт . Финтек үйлчилгээ үзүүлж буй ББСБ-уудын тоо



2022 оны 3 дугаар улирлын байдлаар эдгээр ББСБ-ууд зөвхөн аппликэйшний 1,460,376 зээлдэгчийн 346.8 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь салбарын нийт зээлдэгчийн 88.8 хувь, нийт зээлийн үлдэгдлийн 13.0 хувийг бүрдүүлж байна. Нэг зээлдэгчид дунджаар 237.5 мянган төгрөгийн зээл олгосон нь уламжлалт зээлийн дунджаас 53.1 дахин бага байна.

Энэ төрлийн үйлчилгээ санал болгож байгаа ББСБ-уудын тоо нэмэгдэж, тэдгээрийн зөвхөн финтек зээлийн үлдэгдэл нийт зээлийн үлдэгдлийн 13.0 хувьд хүрсэн, зээлдэгчдийн тоо нь давхардсан тоогоор Монгол Улсын 2021 оны байдлаарх нийт хүн амын 42.8 хувьд хүрсэн зэрэг нь тухайн төрлийн бүтээгдэхүүний эрэлт, хүртээмж хэр их байгааг харуулж байна.

ББСБ-аас олгож байгаа энэ төрлийн зээлийн бүтээгдэхүүнд тавигдах шаардлага, зохицуулалтын орчин байхгүйн улмаас иргэд нэг өрийг нөгөөгөөр санхүүжүүлэх, зээлийн мэдээллийн санд нийлүүлж байгаа мэдээлэл дутмаг байгаагаас нэг зээлдэгч олон газраас зэрэг зээл авах, тухайн төрлийн бүтээгдэхүүнд тавигдах хязгаарлалт байхгүйн улмаас зээлийг зориулалтын бусаар ашиглах, ББСБ-уудын активын чанар муудах зэрэг үр дагавар үүсэх эрсдэлтэй гэж үзэн Санхүүгийн зохицуулах хорооноос нэг талаас салбарын активын чанарыг, нөгөө талаас иргэдийг хамгаалах зорилгоор ББСБ-аас олгох финтек зээлийн бүтээгдэхүүнд өр орлогын харьцааг 70 хувиар тогтоосон.

Өр, орлогын харьцааны хувьд авч үзвэл Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр 2022 оны эхний хагас жилийн байдлаар иргэдийн сарын дундаж цалин 1,544,000 төгрөг байна. Үүнээс нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг суутгавал цэвэр орлого дунджаар 1,246,100.0 төгрөгтэй тэнцэж байна. Харин амьжиргааны баталгаажих доод түвшин 277,800 төгрөг байгаа бөгөөд энэ нь цэвэр дундаж орлого буюу 1.2 сая төгрөгийн 22.3 хувийг эзэлж байна. Иймд иргэд цалин, тэтгэвэр гэх мэт тогтмол орлогоо барьцаалж зээл авсан тохиолдолд зээлийн сарын төлбөр нь татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн дараах орлогын 77.7 хувиас хэтэрвэл наад захын амьжиргааны зардлаа танах эсвэл нэмж зээл авах, зээлээ сунгах шаардлагатай болох тул өрийн дарамт нэмэгдэх, зээлгүйгээр амьдрах боломжгүй болох эрсдэл үүснэ. Дээрх тооцоог 4 ам бүлтэй, 2 хүний цалингийн орлоготой өрхийн хувьд хийхэд зээлийн сарын төлбөр нь өрхийн орлогын 45 хувиас хэтэрвэл өдөр тутмын зайлшгүй хэрэглээгээ санхүүжүүлэх боломжгүй болж байна.

Иймд Санхүүгийн зохицуулах хорооноос ББСБ-ын финтек зээлийн бүтээгдэхүүнд өр, орлогын харьцааг тооцох шаардлагыг тавьж, харилцагчдад амьжиргааны наад захын хэрэгцээгээ хангах орлогыг өөртөө үлдээх нөхцөлийг бүрдүүлсэн бодлогын чухал арга хэмжээ юм.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТӨЛӨӨЛӨЛ ОЛОН УЛСЫН ДААТГАЛЫН ЗОХИЦУУЛАГЧДЫН ХОЛБООНЫ ХУРАЛД ОРОЛЦОО



Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Н.Хүдэрчулуун Чили улсын Сантьяго хотноо болсон Олон улсын даатгалын зохицуулагчдын холбооны 29 дэх удаагийн жилийн тайлангийн хуралд оролцлоо.

Энэ сарын 09–11–ний өдрүүдэд болсон энэхүү хуралд гишүүн орнуудын зохицуулалтын байгууллагын 300 гаруй төлөөлөл оролцож үйл ажиллагааны тайланг хэлэлцэхийн сацуу “Өөрчлөгдөж буй нөхцөл байдал: хөгжиж буй эдийн засаг болон нийгмийн өөрчлөлтөд даатгалын үзүүлэх нөлөө” сэдвийн хүрээнд олон улсын хурал, хэлэлцүүлэг боллоо. Мөн тэгш хуваарилалт болон хүртээмжтэй байдал, өөрчлөгдөж буй хэрэглэгчийн чиг хандлага, макро эдийн засгийн болон цаг агаарын эрсдэл, даатгалын хөрөнгийн шаардлагад тавигдах стандартуудын талаар тусгайлан хэлэлцэж, санал солилцсон юм.

Хурлаар улс орнуудын зохицуулагч байгууллагууд даатгалын салбар дахь цахим хэрэглээ, түүний өөрчлөлт, шинэчлэл нь даатгалын салбарт өсөлтийг авчрах гол хөшүүрэг болж байгаа талаар цохон дурдлаа. Мөн хүртээмжтэй даатгалын зохицуулалтын орчинг сайжруулах замаар даатгалын хүртээмжийг хэрхэн

нэмэгдүүлсэн талаарх Гана, Кени, Коста Рика болон Зимбабве улсуудын жишээ нь оролцогчдын анхаарлыг ихэд татаж байлаа.

Олон улсын даатгалын зохицуулагчдын холбоо нь 1994 онд байгуулагдсан ба өдгөө дэлхийн даатгалын хураамжийн 97 хувийг бүрдүүлдэг 200 гаруй зохицуулалтын байгууллагыг гишүүнчлэлдээ багтаадаг. Санхүүгийн зохицуулах хороо 2007 онд гишүүн байгууллагаар элсэж, нэгдсэн бодлого зохицуулалт, зөвлөмжийг удирдлага болгож авахын зэрэгцээ гишүүн орнуудыг хамарсан судалгаа, шинжилгээнд тогтмол хамрагддаг юм.

БНСУ–ЫН САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОРОО, САНХҮҮГИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАХААР САНАЛ СОЛИЛЦОО



Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал БНСУ–ын Санхүүгийн үйлчилгээний хороо /FSC/–ны орон тооны гишүүн Ким Ен Жэ болон Санхүүгийн хяналтын байгууллага (FSS)–ын тэргүүн дэд дарга Ли Мюн Сүн нартай өнөөдөр уулзлаа.

Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал энэ үеэр Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны талаар товч танилцуулахын зэрэгцээ сүүлийн жилүүдэд хийсэн зарим онцлох ажлын талаар мэдээлэл өглөө. Ялангуяа хөрөнгийн зах зээлийн өсөлтийг нэмэгдүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бодлогоор дэмжих, гадаадын хөрөнгө оруулагчдын болон мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх, санхүүгийн зах зээлд шударга өрсөлдөөнийг бий болгох замаар санхүүжилтийн зардлыг бууруулах чиглэлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн талаар танилцууллаа. Мөн тэрбээр банкны салбарын реформ, төрийн өмчит компаниудын өмчлөлийн хэлбэрийг оновчтой болгож, засаглалыг сайжруулж үе шаттайгаар олон нийтийн хяналттай,

нээлттэй хувьцаат компани болгох хүрээнд хийхээр төлөвлөөд буй ажлынхаа талаар мэдээлэл өгсөн. Ингэснээр Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2–3 дахин өсөх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүнүүд бий болно гэдгийг танилцуулсан юм.

Уулзалтын үеэр зохицуулагч байгууллагууд Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудыг Солонгосын хөрөнгийн биржид давхар бүртгүүлэх, хадгаламжийн бичиг гаргах боломж, эрх зүйн орчныг сайжруулах тухай болон хоёр орны мэргэжилтнүүдийг сургах, мэргэшүүлэх хүрээнд хамтран ажиллах цаашид “Санхүүгийн хянан шалгагчдын түншлэлийн хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэхийн зэрэгцээ шинээр зохицуулалтад ороод буй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэл, зохицуулалтын чиглэлд туршлага солилцох талаар ярилцаж хамтран ажиллахаар санал нэгдлээ.

ДААТГАЛЫН КОМПАНИЙН АЖИЛТНУУДАД ЖУРМЫН ТАНИЛЦУУЛГА, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 558 дугаар тогтоолоор “Эрсдэлд суурилсан хөрөнгийн аргачлалаар тооцсон төлбөрийн чадварын зохистой харьцааны журам”, “Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх заавар”-ыг тус тус баталсан. Уг журам, заавартай холбогдуулж даатгагчаас ирүүлэх тайлан мэдээллийн талаар зөвлөмж, зааварчилгаа өгөх болон бусад хэрэгжилтийг хангуулах зорилгоор даатгалын компаниудын нягтлан бодогч, актуарч, хөрөнгө оруулалтын менежер зэрэг холбогдох ажилтнуудад зориулсан сургалт, танилцуулгыг 10 дугаар сарын 31-ний өдөр зохион байгууллаа.

Даатгалын компаниудыг мэргэжлийн институциональ хөрөнгө оруулагчид болгох, даатгагчийн хуримтлал, нөөцийн үр ашигт байдлыг нэмэгдүүлэх зорилгоор даатгагчийн хөрөнгө оруулалтын төрөл, хэлбэрийг олон улсын нийтлэг жишгийн дагуу нэмэгдүүлэх, ногоон бонд, виртуал хөрөнгө, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хувийн, хамтын хөрөнгө оруулалтын сан,

биржээр арилжаалагддаг сан буюу ETF зэрэгт хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлсэн зохицуулалтуудыг журамд тусгасан. Уг зохицуулалттай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газар, Хяналт шалгалт, зохицуулалтын газрын холбогдох албан тушаалтнууд журамд тусгагдсан үнэт цаас болон ББСБ-ын итгэлцлийн үйлчилгээ, тэдгээрийн онцлог, бүртгэлтэй холбоотой мэдээллийг мөн танилцууллаа.

БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛЭЭС 681.7 ТЭРБУМ ТӨГРӨГИЙГ ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭВ



Санхүүгийн зохицуулах хорооноос санхүүгийн салбарын гуравдугаар улирлын тойм мэдээллийг танилцууллаа. Хэвлэлийн бага хуралд Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэн, Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын дарга Н.Оюунчимэг, Хяналт шалгалт, зохицуулалтын газрын дарга Б.Долгосүрэн нар оролцлоо. Энэ оны гуравдугаар улирлын байдлаар хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоодын хөрөнгө ДНБ-ийн 20.7 хувьд хүрсэн байна. Үүнээс хөрөнгийн зах зээлийн үнэлгээг ДНБ-д харьцуулахад 11.1, даатгалын зах зээл 1.1, ББСБ 7.9, Хадгаламж, зээлийн хоршоо /ХЗХ/ 0.6 хувьтай тус тус байна. Санхүүгийн зохицуулах хорооны нь чиг үүргийнхээ хүрээнд 3,686 зохицуулалттай этгээд, 2,298 даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаанд зохицуулалт, хяналт тавин ажиллалаа.



БАЙР СУУРЬ

АРИЛЖААНЫ БАНКНУУДЫН ХУВЬЦАА ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ТОМООХОН ӨӨРЧЛӨЛТ ШИНЭЧЛЭЛИЙГ БИЙ БОЛГОНО

Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөнтэй ярилцлаа.



Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс Банкны тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Монголбанкт хамтран “Банкийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хянах түр журам”-ыг 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн, “Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам”-ыг 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хамтарсан тушаалаар тус тус баталсан.

Гэвч өнгөрсөн жилүүдэд коронавируст цар тахал болон бусад дэлхийн хэмжээнд гарч буй таагүй үйл явдлуудын улмаас олон улсын эдийн засаг, санхүү, хөрөнгийн зах зээлд учруулж буй хүндрэлтэй нөхцөл байдал, хил гаалийн хорио цээр зэрэг тодорхой бус байдлаас шалтгаалан Монгол Улсын санхүү, эдийн засгийн нөхцөл байдал ч мөн тодорхойгүй, эмзэг байгаатай холбоотойгоор Монголбанкны зүгээс арилжааны банкнуудын активт чанарын үнэлгээг хийх нь зүйтэй гэж үзсэн.

Тиймээс УИХ-аас 2022 оны хаврын чуулган, Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар системийн ач холбогдолтой банкнуудын олон нийтэд хувьцаагаа санал болгон гаргаж, компанийн хэлбэрийг өөрчлөх хугацааг дахин нэг жилээр сунгахаар холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар хөрөнгийн зах зээлд чанартай, эрсдэл бага, өгөөж өндөртэй бүтээгдэхүүн санал болгон гаргах боломжийг нэмэгдүүлэх, гадаад, дотоодын мэргэжлийн хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах, арилжааны банкнуудаас санхүүгийн тогтвортой байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад ач холбогдолтой юм.

Хэдийгээр системийн ач холбогдолтой банкнуудын олон нийтэд хувьцаа гаргах ажиллагааны эцсийн хугацаа нэг жилээр сунгагдсан боловч өнгөрсөн 2021 онд “Богд банк” ХХК хувьцаагаа Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэн олон нийтэд хувьцаагаа санал болгон гаргаж, анхдагч зах зээлээс 32 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн бол системийн нөлөө бүхий банкнуудаас “Төрийн банк” ХХК нээлттэй хувьцаат компани болох ажлыг түүчээлж 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр олон нийтэд нийт хувьцааныхаа 5 хувийг буюу 37,475,000 ширхгийг, нэг бүрийг нь 590 төгрөгөөр санал болгон худалдаж эхэлсэн бөгөөд санал болгосон эхний өдрөө л бүх хувьцаагаа хөрөнгө оруулагчдад худалдаж, нийт 25.4 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн.

Мөн “Голомт банк” ХХК-аас нээлттэй хувьцаат компани болох зөвшөөрлөө 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр Санхүүгийн зохицуулах хорооноос авсан бөгөөд 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс 30-ны өдрийг дуустал анхдагч зах зээлийн арилжаа үргэлжилж нийт 174.8 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлээд байна.

УИХ-аас арилжааны банкнуудын олон нийтэд хувьцаагаа санал болгон гаргах ажиллагаа буюу IPO-г Монголбанкнаас хийгдэж буй активын чанарын үнэлгээг бүрэн хийгдсэний дараа хэрэгжүүлэхээр шийдвэрлэсний ач холбогдлыг Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс юу гэж харж байна?

УИХ-аас холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулан олон нийтэд хувьцаа санал болгох ажиллагааг тодорхой хугацаагаар хойшлуулах шийдвэр гаргасан. Санхүүгийн зохицуулах хороо нь эрх зүйн байдлын тухай хуулиараа дотоодын хөрөнгийн зах зээлд гарч буй өндөр өсөлт, хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлийг хэвээр хадгалж, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах, хөрөнгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах чиг үүрэгтэй болохынхоо хувьд Монголбанкнаас активын чанарын үнэлгээг бүрэн хийж, үнэлгээний үр дүнг албан ёсоор гаргасны дараа банкны системд нөлөө бүхий банкнуудын нийтэд санал болгон гаргах хувьцааг бүртгэх нь зүйтэй гэсэн бодлогын байр суурьтай байгаа бөгөөд энэ нь цаг үеийн нөхцөл байдалтай нийцэхээс гадна ирээдүйд гарч болзошгүй эрсдэлээс хөрөнгө оруулагчдыг хамгаалах тул үнэлгээний үр дүнг албан ёсоор гаргасны дараагаар анхдагч зах зээлд арилжаалах зөвшөөрөл өгөх нь зүйтэй гэсэн зарчмын байр суурийг баримталсан.

Монголбанкнаас системд нөлөө бүхий таван банкны удирдлагуудад Активын чанарын үнэлгээний үр дүнгээр нэмж байгуулах эрсдэлийн сан болон бусад холбогдох тохируулгын гүйлгээг тухайн банкны 2022 оны 8 дугаар сарын тайлан тэнцэлд тусгуулах, 2022 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт активт байгуулсан эрсдэлийн сангийн хэмжээг анхдагч зах зээлд хувьцаагаа гаргах хүртэл бууруулахгүй байх арга хэмжээг авч ажиллах үүрэг даалгавар өгсөн бөгөөд активын чанарын үнэлгээний үр дүнгээр тооцсон тохируулгын гүйлгээг дээрх банкнуудын тайлан, тэнцэлд тусгасны дараах байдлаар банк тус бүрийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлага хангагдаж байгаа учир одоогоор Санхүүгийн зохицуулах хороонд хандан нээлттэй хувьцаат компани болох хүсэлтээ өгсөн тус банкнуудад олгох зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж өгөхийг хүссэн хүсэлтийг албан бичгээр ирүүлсэн.

Үүний дагуу Монголбанкнаас системийн нөлөө бүхий банканд хийгдсэн активын чанарын үнэлгээний шалгалтын үр дүн эцэслэгдэн гарсан ба Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3-т заасан Монголбанкнаас холбогдох зөвшөөрлийг ирүүлсэн тул Санхүүгийн зохицуулах хорооноос тус хүсэлтээ өгсөн банкнуудын нийтэд санал болгон анх удаа гаргах хувьцааг бүртгэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянаж, шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж байна.

Арилжааны банкнууд олон нийтийн компани болох бэлтгэл хангагдаж, дүрэм, журмын зохицуулалтын орчин хэр зэрэг бүрдсэн гэж үзэж байна?

Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкны зүгээс системийн нөлөө бүхий банкнууд хөрөнгийн зах зээл дээр IPO хийх замаар

нээлттэй хувьцаат компани болох ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, олон улсын жишигт нийцүүлэх чиглэлээр өмнө дурдсан “Банкийг хувьцаат компани хэлбэрээр өөрчлөх төлөвлөгөө ирүүлэх түр журам” болон “Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам”-ыг хамтран батлаад байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос 2021 онд “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын олон улсад нийтлэг хэрэглэгддэг стандарт, зохицуулалтын хүрээнд анхдагч зах зээлийн арилжааг андеррайтерийн компани, арилжаа эрхлэх байгууллагын аль нэгээр зохион байгуулах, үнэт цаас бүртгүүлэхэд шаардлагатай баримт бичгийг хялбаршуулж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр хөндлөнгийн дүгнэлт гаргагч байгууллагуудын дүгнэлтийн чанар, хараат бус байдлыг дээшлүүлэх, хоёрдогч зах зээлийн арилжааг тогтворжуулж, үнэ ханшны хэт савлагаанаас сэргийлэх арга механизмыг тусгаж, хувьцаат компаниудын мэдээлэл тайлагналын ил тод байдлыг хангуулж, мэдээллийг тухай бүр хүргэх зохицуулалтыг дээрх журмаар бүрдүүлээд байна.

Мөн Санхүүгийн зохицуулах хорооноос 2022 онд Компанийн засаглалын кодексийг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD), Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (IOSCO) болон бусад байгууллагаас гаргасан зөвлөмж, стандартад тулгуурлан өөрийн орны онцлогт тохирсон хэлбэрээр боловсруулж батлаад байна. Ингэснээр арилжааны банкнууд нээлттэй хувьцаат компани болохтой холбоотой дүрэм, журмын зохицуулалтын орчин бүрэн бүрдсэн гэж хэлж болно.

Түүнчлэн, Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс банкны системд нөлөө бүхий банкнуудын компанийн хэлбэрийг өөрчлөн зохион байгуулах замаар нээлттэй хувьцаат компани болохтой холбоотойгоор хүсэлтээ өгсөн банкнуудын төлөөллүүдтэй холбогдох уулзалтуудыг тогтмол зохион байгуулж, шаардлагатай зөвлөмж, мэдээллийг өгч хамтран ажиллаж байна.

Банкнууд хувьцаат компани болж хөрөнгийн бирж дээр гарахад зах зээл, хөрөнгө оруулагчид хэр хүлээлттэй байгаа вэ?

УИХ-аас хууль батлагдсанаас хойших хугацаанд олон нийтийн зүгээс арилжааны банкнуудын олон нийтэд санал болгон гаргасан хувьцаанд хөрөнгө оруулалт хийж, хувьцаа эзэмшигч болох сонирхол өндөр байгаа нь ажиглагдаж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд Санхүүгийн зохицуулах хорооноос мэргэжлийн хөрөнгө оруулагчдын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр бодлогын арга хэмжээ

авч хэрэгжүүлсний үр дүнд институциональ хөрөнгө оруулагчид буюу хамтын нээлттэй, хаалттай хөрөнгө оруулалтын сангууд олноор бий болсон.

Ингэснээр хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүний тоо нэмэгдэж, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоо, сонирхол өсөх, үйл ажиллагаа нь идэвхжих, улмаар гадаадын хөрөнгө оруулалтын урсгал дотоодын зах зээлд орох давуу тал бий болсон бөгөөд цаашид ч аж ахуйн нэгжүүдээс IPO хийх, бонд гаргах замаар хөрөнгө босгох хүлээлт өндөр байна.

Арилжааны банкнууд хувьцаагаа олон нийтэд санал болгон гаргасан нөхцөлд анхдагч зах зээлийн арилжаа амжилттай зохион байгуулагдаж, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхол, эрэлт, хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээ бий болж, хөрөнгийн зах зээлийн багтаамж, хөрвөх чадвар эрс нэмэгдэж, олон тулгуурт санхүүгийн тогтолцоо бүрдэх боломж бүрдэнэ гэж Санхүүгийн зохицуулах хорооноос үзэж байна.

Арилжааны банкнууд олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсноор санхүүгийн болон хөрөнгийн зах зээлийн өсөлт, хөгжилд ямар үр нөлөө үзүүлнэ гэж Санхүүгийн зохицуулах хороо үзэж байна?

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар Санхүүгийн зохицуулах хороо нь ил тод нээлттэй зах зээлийн орчин бүрдүүлэх, шинэ төрлийн эрсдэл бага, өгөөж өндөртэй санхүүгийн хэрэгслүүдийг дэмжих, зах зээлд санал болгох зөвшөөрлийг олгох, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Энэхүү чиг үүргийн хүрээнд системийн ач холбогдолтой арилжааны банкнууд болон бусад банкнууд хувьцаагаа олон нийтэд санал болгон гаргаж, шаардлагатай санхүүжилтээ татан төвлөрүүлснээр нийт санхүүгийн салбарт, нэн ялангуяа хөрөнгийн зах зээлд томоохон өөрчлөлт шинэчлэлийг бий болгоно гэж харж байна. Тухайлбал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадварын түвшин нэмэгдэж, хөрөнгө оруулагч иргэд, аж ахуйн нэгжүүд арилжааны банкны хувьцаанд хөрөнгө оруулалт хийх, үнэт цаас гаргагчийн засаглал, тайлагналын ил тод байдал хангагдах нөхцөл бүрдэх юм.

Түүнчлэн өнгөрсөн 30 жилийн хугацаанд санхүүгийн зах зээлийн 90-ээс дээш хувийг арилжааны банкнууд дангаар эзэлж байсан бол нээлттэй хувьцаат компани болж, хөрөнгийн зах зээлийн тоглогч болсноор зах зээлд шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, хөрөнгө оруулагчдын дотоодын зах зээлд хөрөнгө оруулах сонирхлыг татах, хөрөнгийн зах зээлийн зохицуулалт, нэгдсэн санхүүгийн хяналтын орчныг бий болгож олон улсын жишигт нийцүүлж хөгжүүлэхэд томоохон нөлөө үзүүлнэ.

Банкны системд нөлөө бүхий 5 банк олон нийтэд анх удаа хувьцаагаа санал болгох замаар нээлттэй хувьцаат компани болж нийт 430 гаруй тэрбум төгрөгийг татан төвлөрүүлснээр хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 5.5 их наяд төгрөгөөр нэмэгдэж, улмаар нийт хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 10 их наяд төгрөгт хүрнэ гэсэн урьдчилсан тооцоо гарсан.

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

НОГООН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /БАЛАНСЫН ТАЙЛАН/

Сүүлийн үед уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой санхүүжилттэй холбоотой ногоон төслүүдийг санхүүжүүлэх ногоон, тогтвортой санхүүгийн бүтээгдэхүүн болох зээл, бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас зэрэг гарах болсон. Эдгээр бүтээгдэхүүний зээлийн чанар, өртгийг тооцох хэрэгцээ байдаг тул санхүүгийн тайланг ногоон болгох шаардлагатай байна. Том зургаар нь харвал уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, түүнд дасан зохицож буй байдлыг хэмжих үзүүлэлт болох юм.

Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл нь зээлийн эрсдэлд нөлөөлдөг тул уур амьсгалын өөрчлөлтийн өртгийг тооцож үйлдвэрлэл болон байгаль орчны хоорондын холбоо хамаарлыг үнэлэх, өгөгдөл үүсгэхэд ач тустай.

Английн төв банк 2020 онд мөнгөний багцтай холбоотой уур амьсгалын эрсдэлийг тайлагнасан анхны банк болж байсан. Тайланд уур амьсгалын эрсдэлтэй холбоотой үйл ажиллагаа, хэрхэн түүнийг удирдаж байгаа талаарх үнэлгээг хийсэн. Тайлагнал нь компанийн бондын багцад багтсан бүтээгдэхүүний дундаж дэлхийн дулаарал 3.5 цельс ба Парисын хэлэлцээрээр цельсийн 2 градусаас бага түвшинд байлгах зорилгоос хол байгаа гэж Английн төв банкны уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үйл ажиллагаа хариуцсан захирал Сара Брийдэн хэлсэн. Их Британийн Засгийн газрын ямар ч бонд ногоон биш тул бондын багц дахь ногоон байх хэмжээг бууруулсан байна. Төв банкны хувьд ногоон бондын зах зээл хөгжөөгүй нь санхүүгийн байдлын тайланг ногоон болгоход Төв банканд тулгарч буй нэг асуудал юм.

Дэлхий даяар амьдарч буй гарагаа доройтуулахгүй байх хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх эрэлт их ба уг эрэлт нийлүүлэлтээ даваад байна. Энэ нь ногоон бонд гаргах хөшүүрэг боловч хөрөнгө удирдлагын компаниудад ногоон гэдгийг ялгах үүрэг оногдсон.

Ногоон байх гэдэг нь хялбар бус: Төв банкнуудын хувьд санхүүгийн байдлын тайландаа олон улсын нөөц болон мөнгөний үйл ажиллагааны багц гэсэн хоёр аргаар ногоон багцаа бүрдүүлдэг. Олон төв банкнууд ногоон төслийг санхүүжүүлэхэд зээл олгогчдыг хөшүүрэгдэж эхэлсэн. Зээл олгогчдын хувьд ногоон төсөлд зээл олгоход хөрвөх чадварын асуудал, ногоон бондын талаарх ойлгомжгүй удирдамжийн улмаас төвөгтэй байдаг. Ногоон гэж

юу байдаг, яаж тооцоолдог талаарх нарийн тодорхойлолт байхгүй бол “ногоон угаалт” буюу ногоон төсөл гэж хууран мэхлэх эрсдэл тулгардаг байна. Тийм учраас Ногоон таксономийг боловсруулдаг ба олон улсад БНХАУ болон Европын холбооноос гаргасан ногоон таксономийг хэрэглэдэг. Европын төв банкаас судалгаа хийж, ногоон хөрөнгийн харьцааг 7.9 хувь гэж тооцоолсон. Европын холбооны таксономд орсон хөрөнгүүдийн 8.0 орчим хувь нь л ногоон хөрөнгийн тодорхойлолтыг хангаж байна.

Мөнгөний үйл ажиллагаа: Төв банк Засгийн газрын бонд дээр нэмж корпорацийн болон банкны бонд худалдан авч багцаа бүрдүүлдэг. Гэсэн хэдий ч капиталд чиглэсэн компаниуд карбонд чиглэж байна. БНХАУ-ын Төв банк нүүрсэд чиглэсэн санхүүгийн томоохон урсгалыг бий болгосныг үргэлжлүүлж байгаа бөгөөд АНУ-ын Холбооны нөөцийн банк чулуун нүүрсний (fossil fuel) санхүүжилтийг нэмэгдүүлэн ажиллаж байгаа бол Японы төв банк эрчимтэйгээр уг санхүүжилтийг дэмжиж байна.



ФИНТЕК БА РЕГТЕК

ДЭЛХИЙН ФИНТЕКИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА, ТӨРӨЛ ХЭЛБЭР

Банк болон бусад санхүүгийн салбарын байгууллагууд үйлчилгээгээ шуурхай хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, мөн технологийн хөгжлийг даган төвлөрсөн санхүүгийн үйлчилгээний зардлыг бууруулах, цаг хугацааг хэмнэх зорилгоор финтек үйлчилгээ дэлхий дахинд түлхүү хөгжиж, тэдгээрийн хууль эрх зүйн орчин боловсронгуй болж байна. Энэ удаагийн дугаараар дэлхийн санхүүгийн зах зээл дээр түлхүү хэрэглэгдэж байгаа финтекийн бүтээгдэхүүний хэлбэрүүдийг та бүхэнд танилцуулахаар бэлтгэлээ.

ХИЙМЭЛ ОЮУН УХААН БОЛОН БОТ



Утасны автомат хариулагчаас эхлээд робот технологи ашиглан санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээ. Хиймэл оюун ухаан нь маш өргөн

цар хүрээг хамарсан өгөгдлийн санг автоматжуулах боломжийг олгож, ингэснээр цаг хугацаа, зардал хэмнэх болсон. Түүнчлэн тус технологи нь робот зөвлөхийн хөгжүүлэлтэд ашиглагдах гол суурь технологи болж байгаагаас гадна хэрэглэгчдийн зан төлөв, дадал хэвшлийг хянах замаар санхүүгийн залилан, хууран мэхлэлтийг илрүүлэх боломж олгож байна.

КРАУДФАНДИНГ



Төсөл болон бизнесийг санхүүжүүлэх зорилгоор онлайн платформоор дамжуулан олон тооны хувь хүнээс хөрөнгө оруулалт татах технологи.

Энэхүү финтекийн бүтээгдэхүүн нь үндсэн 4 төрөлтэй бөгөөд өнөөгийн байдлаар дэлхий нийтэд 14 хувилбараар санхүүгийн салбарт ашиглаж байна.

- Зээлд суурилсан краудфандинг буюу P2P
- Өмч хөрөнгөд суурилсан краудфандинг
- Шагналд суурилсан краудфандинг
- Хандивт суурилсан краудфандинг

ДИЖИТАЛ БАНК



Банкны уламжлалт бүтээгдэхүүн, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, зайнаас санал болгодог. Дижитал банкны үйлчилгээ нь маш өндөр түвшний автомат үйл ажиллагаа

бүхий веб суурьтай үйлчилгээ бөгөөд түүнчлэн банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээг хүргэх, төлбөр тооцоог гүйцэтгэх хүрээнд санхүүгийн байгууллага хоорондын үйл ажиллагааг холбох зорилгоор мөн ашиглаж байна. Тус үйлчилгээ нь хэрэглэгчдэд гар утас, компьютер, АТМ зэрэг төхөөрөмжөөр дамжуулан санхүүгийн үйлчилгээг түргэн шуурхай хангах боломж олгодог тул эрэлтээ дагаад гар утсаар дамжуулан хийгдэж буй санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын тоо ч мөн адил нэмэгдэж байна.

ГАР УТАСНААС САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ /МОБАЙЛ БАНК/



Интернэт орчинд хөдөлгөөнт төхөөрөмж (гар утас, таблет)-ийг ашиглан санхүүгийн үйлчилгээ авах технологи. Хүмүүс гар утсыг илүү их

ашиглахын хэрээр санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ гар утсанд суурилах болсон. Хөгжил буурай орнууд, ялангуяа Африкийн орнуудын хувьд гар утасны технологид суурилсан дижитал валютын хэрэглээ өндөр байгаа бөгөөд энэ нь эмэгтэйчүүд болон банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээнээс алслагдсан хөдөө орон нутгийн иргэд зэрэг нийгмийн хамгийн эмзэг бүлгүүдийн санхүүгийн зах зээл дэх оролцоог нэмэгдүүлж байгаа тухай Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгээс гаргасан “Санхүүгийн хүртээмж дэх финтек тайлан”-д тусгасан байна.

НУУЦЛАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, БИОМЕТРИК



Царай, хурууны хээ, дуу хоолойг таниулж, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх технологи. Өнөөгийн дижитал эрин үед цахим халдлага нь нийгмийн

тулгамдсан асуудлуудын нэг болоод байгаа бөгөөд финтекийн салбарын хувьд цахим аюулгүй байдлыг нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлага тулгарч байна. Энэхүү асуудлыг шийдвэрлэх боломж нь биометрик технологи бөгөөд хамгаалалт нь зөвхөн биометрик баталгаажуулалтыг шаарддаг боловч аппликэйшнд нэвтрэх, нууц код хэрэглэх үйл явцыг илүү хялбар бөгөөд түргэн шуурхай болгох давуу талыг олгож байгаа юм.

БЛОКЧЭЙН БОЛОН КРИПТОВАЛЮТ



Байршлаас үл хамааран төвлөрсөн сервер удирдлагын функцгүйгээр өөр хоорондоо шууд холбогдож арилжаа хийх технологи. Блокчэйн технологи нь мэдээллийн ил тод байдлыг хангах

хүрээнд маш нээлттэй болж байгаа тул финтекийн шинэ гарааны бизнес эрхлэгчид тус технологийг өргөн ашиглах хандлагатай байна. Санхүүгийн үйл ажиллагааг автоматжуулах, ухаалаг гэрээ хэлэлцээрийг хийх боломжийг тус технологи олгож байгаа нь түүний өөр нэгэн давуу тал болж байна.

ВАЛЮТ АРИЛЖАА



Цахим валютын бирж нь улс хооронд болон дотооддоо валют солилцох интернэтэд суурилсан платформ.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



Хувьцаа, бонд болон бусад төрлийн хөрөнгө оруулалтын цахим арилжаа. Хөрөнгө оруулалтын боломжуудыг үнэлэх, багцыг оновчтой болгох,

эрсдэлийг бууруулах зорилгоор их өгөгдөл, хиймэл оюун ухаан, машин сургалт зэрэг дэвшилтэт технологийг нэвтрүүлж байна.

Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ нь автоматжуулсан зөвлөхүүд буюу “робот зөвлөхүүд”-ийн хэрэглээгээр өөрчлөгдөх болсон. Робот зөвлөхүүд нь хүний оролцоогүйгээр хөрөнгө оруулагчдад туслах, хөрөнгө оруулалтын зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээг үзүүлж байна.

ХӨНГӨЛӨЛТ УРАМШУУЛЛЫН СИСТЕМ



Банк болон бичил санхүүгийн байгууллагууд байнгын үйлчлүүлэгчдэдээ зориулж хэрэглэгчийн төлбөрийн гүйлгээ, хадгаламжийн үлдэгдэлд оноо тооцох,

хөнгөлөлт, урамшуулал олгох зэрэгт дижитал технологийг ашиглаж байна.

МӨНГӨН ГҮЙВУУЛГА



Улс хооронд болон дотооддоо технологиор дамжуулан мөнгөн гуйвуулгын үйлчилгээ авах хэлбэр.

Шимтгэл өндөртэй, оочир дараалал ихтэй банкны үйлчилгээнээс татгалзаж, технологи ашиглан мөнгөн гуйвуулгын шинэ хэлбэрүүдийг нэвтрүүлж эхэлснээр зардлыг бууруулах, шуурхай бөгөөд цаг хугацаа хэмнэх зэрэг давуу талуудыг бий болгож байна.

СУДЛААЧИЙН ИНДЭР

ДААТГАЛЫН ЭРСДЭЛ ШИЛЖҮҮЛЭХ УЛАМЖЛАЛТ БУС САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТ /ХУРААНГУЙЛСАН/

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гүйцэтгэсэн:
Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа,
хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн С.Будбаяр
budbayar@frc.mn



ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны ажлаар даатгалыг эрсдэлийг шилжүүлэх уламжлалт бус санхүүгийн арга хэрэгсэл, түүний өнөөгийн байдлыг судлахаар дэлхийн давхар даатгалын үйл ажиллагаагаар тэргүүлэгч орнууд болох Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Швейцарын Холбооны Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Америкийн Нэгдсэн Улсын туршлагыг судаллаа. Судалсан улсуудын эрсдэл шилжүүлж буй нийтлэг уламжлалт бус санхүүгийн хэрэгсэл нь гамшгийн бонд, давхар даатгалын side-sag, даатгалын эрсдэлд суурилсан үнэт цаас зэрэг байв. Судалсан улсуудын эрсдэлийг шилжүүлэх уламжлалт бус хэрэгслийг зохицуулж буй байдал нь харилцан адилгүй байна.

УДИРТГАЛ

Даатгалын үнэлгээ өндөртэй даатгалын гэрээг дотоодын даатгагчид дангаар хийх боломжгүй нөхцөлд уламжлалт аргаар

буюу гадаадын даатгагчаар даатгуулдаг. Олон улсад уламжлалт бус санхүүгийн буюу Alternative risk transfer /ART/-ийг ашиглан эрсдэлийг шилжүүлдэг ба энэ нь даатгагч болон давхар даатгагчдад илүү өргөн эх үүсвэрээс хөрөнгө босгох, хөрөнгө оруулалтын багцыг сайжруулах, даатгалын эрсдэлийг тараан байршуулах, даатгалын компаниудын эрсдэл даах чадамжийг нэмэгдүүлэх зэрэг чухал ач холбогдолтой.

Манай улсын давхар даатгалын зах зээл гаднын давхар даатгагчдаас ихээхэн хамааралтай байж, даатгалын хураамж хэлбэрээр их хэмжээний валютын гадагш урсгалыг бий болгосоор байна. Энэ нь нэг талаас дотоодын давхар даатгалын зах зээлийн хөгжил хангалтгүй, нөгөө талаас даатгалын компаниудын эрсдэл хүлээн авах механизм боловсронгуй бус байгаагаас гадагшаа их хэмжээний мөнгөн урсгал бий болж байгааг харуулж байна. Дотоодын давхар даатгалын салбарыг хөгжүүлж чадсанаар гадагш чиглэх валютын урсгалыг зохицуулах, бууруулах, даатгалын зах зээлийн хөгжлийг дэмжих хөшүүрэг гэж харах боломжтой.

Санхүүгийн зохицуулах хороо нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсын Засгийн газрын 2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсаны дагуу “Даатгалын тухай хууль”-ийг шинэчлэн найруулахаар үзэл баримтлал болон хуулийн төслийг боловсруулан, УИХ-д өргөн барихаар ажиллаж байна. Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 50.1.2 /даатгалын эрсдэл шилжүүлэх уламжлалт бус санхүүгийн хэрэгсэл ашиглан даатгалын эрсдэлийг шилжүүлж болно/, 52.1 /даатгагч нь даатгалын эрсдэлийг шилжүүлэх уламжлалт бус

санхүүгийн хэрэгслийг ашиглан даатгалын эрсдэлийг хөрөнгийн зах зээлд гаргаж болно/, 52.2 /52.1–д заасан эрсдэл шилжүүлэх уламжлалт бус санхүүгийн хэрэгслийг ашиглах үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг Хороо батална/ гэсэн заалтуудаас үндэслэн олон улсад ямар аргачлалаар даатгалын эрсдэлийг шилжүүлдэг, зохицуулагч байгууллагын зүгээс хэрхэн хянаж зохицуулдаг талаар судлах зорилгоор энэхүү судалгааг хийлээ.


ОЛОН УЛСЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Олон улсад даатгалын компаниуд дараах 2 аргаар эрсдэлээ шилжүүлдэг байна:

1. Уламжлалт арга буюу давхар даатгагчид шилжүүлэх;
2. Уламжлалт бус санхүүгийн хэрэгсэл ашиглан шилжүүлэх.

Хөрөнгийн зах зээлд оролцох замаар дотоодын давхар даатгалын зах зээлийг хөгжүүлэх, гаднын хөрөнгө оруулагчдыг татах нэг арга зам бол эрсдэл шилжүүлэх юм. ART нь эрсдэлд өртсөн зүйлийг уламжлалт даатгал болон давхар даатгалаас бусад арга техникийг ашиглах процесс юм.

Зураг. Олон улсын даатгалын компаниудын эрсдэлийг шилжүүлж буй зураглал



ДААТГАЛЫН ЭРСДЭЛД СУУРИЛСАН ҮНЭТ ЦААС /INSURANCE-LINKED SECURITIES/

Даатгалын эрсдэлд суурилсан үнэт цаас /ДЭСҮЦ/-ыг даатгалын хохирлын тохиолдлоор үнэлдэг санхүүгийн хэрэгсэл гэж тодорхойлдог. Үүнд: байгалийн сүйрэл, гэнэтийн эрсдэлтэй холбоотой эрсдэлийг санхүүгийн зах зээлтэй холбодог өвөрмөц санхүүгийн хэрэгсэл.

1990–ээд онд даатгагчдад дэлхийн хөрөнгийн зах зээлийн томоохон нөөцийг ашиглах арга зам бий болсон үед ДЭСҮЦ–ны суурь бий болж, хөгжиж эхэлсэн.

Дэлхийн давхар даатгалын салбар дахь ДЭСҮЦ–ны нийт хэмжээ нь 95 тэрбум ам.доллар ба энэ нь нийт давхар даатгалын

боломжит чадавхын 20 орчим хувийг эзэлж байна. 2012–2018 оны үеийг их өсөлтийг жил гэж нэрлэдэг ба тус хугацаанд ДЭСҮЦ нь гамшгийн бондын гол эх үүсвэр болсон.

ГАМШГИЙН БОНД /CATASTROPHE BOND/

Гамшгийн бонд нь ДЭСҮЦ–ны нэг төрөл бөгөөд даатгалын үнэт цаасжуулсан хэлбэр гэж нэрлэгддэг. Гамшгийн бонд нь гамшгийн үед /хар салхи, газар хөдлөлт, гал түймэр, бусад байгалийн гамшиг/ даатгалын компаниудын хөрөнгө босгох зорилго бүхий өндөр өгөөжтэй өрийн хэрэгсэл.

Даатгагчид гамшиг, тэр дундаа байгалийн гамшгийн эрсдэлийг ихэвчлэн давхар даатгагчид шилжүүлдэг. Гамшгийн хохирлын хэмжээ нь даатгалын компанигай байгуулсан гэрээгээр


тохиролцсон дүнгээс давсан тохиолдолд давхар даатгагч нь даатгалын компанийн хүлээх эрсдэлээс давсан хэсгийг нөхөн төлдөг.

ДАВХАР ДААТГАЛЫН SIDECAR /REINSURANCE SIDECAR/

Давхар даатгалын sidecar гэдэг нь даатгалын компанитай байгуулсан гэрээнд хөрөнгө оруулалт авахыг хүссэн санхүүгийн байгууллага юм. Sidecar компанийг ихэвчлэн давхар даатгалын компаниуд байгуулдаг ч ердийн даатгалын компаниуд мөн байгуулж болдог.

Байгуулж буй квотын гэрээнд давхар даатгалын компани болон даатгагч нь шимтгэл болон алдагдлын хувийг тодорхой хувиар хуваадаг. Давхар даатгалын sidecar-д оролцдог хөрөнгө оруулагчид андеррайтерийн бодлогод зааснаар хураамж, алдагдлыг хуваана. Ингэхдээ ашиг, алдагдал нь оруулсан хөрөнгө оруулалтай пропорциональ буюу хувь тэнцүүлсэн байдаг.

Зураг. Салбарын хохирлын баталгааны зураглал



Босго хэмжээ болон эрсдэлийн дээд хэмжээг урьдчилан тогтоож, гэрээнд тусгадаг.

МОНГОЛ УЛСЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Даатгалын тухай хуульд зааснаар даатгагч нар өөрийн хүлээж авах эрсдэлээс давсан хэсгийг уламжлалт аргаар буюу давхар даатгалын компанид хэсэгчлэн эсхүл бүрэн шилжүүлж болдог. Даатгалын үнэлгээ ихтэй даатгалын гэрээг дотоодын даатгагчид дангаар хийх боломжгүй нөхцөлд үнэлгээний ихэнх хэсгийг


Давхар даатгалын sidecar-г ашиглан хөрөнгө босгосон компаниудын дүнг судлахад Swiss Re компани нь хамгийн их буюу 1.1 тэрбум ам.долларын хөрөнгө босгосон байна

САЛБАРЫН ХОХИРЛЫН БАТАЛГАА /INDUSTRY LOSS WARRANTY/

Олон давтагддаг байгалийн аюул, эрсдэлээс хамгаалахын тулд барьцаалсан давхар даатгал болон даатгалын эрсдэлд суурилсан үнэт цаасны сангийн эрсдэлийг хүлээдэг компаниудын түгээмэл ашигладаг уламжлалт бус санхүүгийн хэрэгсэл ба даатгалын болон дериватив гэрээ хэлбэрээр байдаг. Даатгалын салбарын нийт алдагдал нь тогтоосон дээд хэмжээнээс давсан тохиолдолд салбарын хохирлын баталгаанаас авдаг. Босго хэмжээ болон дээд хувь хэмжээг урьдчилан тогтоож, гэрээнд тусгадаг.

гадны даатгагчаар даатгуулах, давхар даатгагчид шилжүүлэх тохиолдлууд гарсаар байна. Олон улсад даатгалын компаниуд давхар даатгалаас гадна уламжлалт бус санхүүгийн хэрэгслийг ашиглан эрсдэлээ шилжүүлж байгаа бол одоогоор Монгол Улсад даатгалын эрсдэл шилжүүлэх уламжлалт бус санхүүгийн хэрэгсэл хөгжөөгүй байна.

Зураг. Монгол Улсын даатгалын эрсдэлийг шилжүүлж буй зураглал



Манай улсын давхар даатгалын үйл ажиллагааны талаар дурдвал: 2017–2021 онд буюу сүүлийн 5 жилийн хугацаанд даатгалын компаниудын нийт хураамжийн орлогын 31.7 хувь буюу нийт 308.7 тэрбум төгрөгийг гадагш давхар даатгалын хураамжид шилжүүлсэн бол 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт

хураамжийн орлогын 20.5 хувь буюу нийт 25.4 тэрбум төгрөгийг гадагш давхар даатгалын хураамжид шилжүүлсэн. Тус хугацааны хураамжийн орлого, гадагш шилжүүлсэн болон дотоодын давхар даатгалын нийт хураамж, тэдгээрийн эзлэх хувийг тооцоолоход дараах байдалтай байна:

Хүснэгт. 2019–2022. II улирлын хураамжийн орлогод эзлэх гадагш шилжүүлсэн болон дотоодын давхар даатгалын хувь

	Ердийн болон урт хугацааны даатгалын хураамж /тэрбум төгрөгөөр/	Гадагш шилжүүлсэн давхар даатгалын хураамжийн зардал /тэрбум төгрөгөөр/	Эзлэх хувь $/3/ = /2/ : /1/$	Дотоодын давхар даатгалын хураамж /тэрбум төгрөгөөр/	Эзлэх хувь $/5/ = /4/ : /2/$	Даатгалын үнэлгээ /дотоодын давхар даатгагчийн/ /тэрбум төгрөгөөр/
	/1/	/2/		/4/		/6/
2019	196.6	57.3	29.1%	2.1	3.7%	393.9
2020	201.5	66.8	33.2%	3.6	5.4%	2,224.4
2021	243.3	84.4	34.7%	4.2	4.9%	1,334.8
2022.I	50.5	12.2	24.2%	0.9	7.4%	573.2
2022.II	124.3	25.4	20.5%	1.7	6.7%	820.2

Тайлбар: 2022 оны эхний хагас жилийн байдлаар даатгалын компаниуд нийт 124.3 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажилласнаас 20.5 хувь буюу 25.4 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамжид зарцуулсан бөгөөд үүний 6.7 хувь буюу 1.7 тэрбум төгрөгийг дотоодын давхар даатгагч болох “Үндэсний давхар

даатгал” ХК–д төлсөн. Тус хугацаанд 820.2 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий даатгалын зүйлийг 1.7 тэрбум төгрөгөөр даатгасан байна. Жил ирэх тутам давхар даатгагчид төлсөн хураамжийн зардлын хувь нэмэгдэж байгаа ч 8.0 хувиас давахгүй байна.


	Дотоодын давхар даатгалын хураамж /тэрбум төгрөгөөр/	Даатгалын үнэлгээ /дотоодын давхар даатгагчийн/ /тэрбум төгрөгөөр/	Харьцуулалт
2019	2.1	393.9	187.6
2020	3.6	2,224.4	617.9
2021	4.2	1,334.8	317.8
2022.I	0.9	573.2	636.9
2022.II	1.7	820.2	482.5

Гэсэн хэдий ч дотоодын давхар даатгагчийн даатгаж буй зүйлсийн даатгалын үнэлгээ маш өндөр байна. /2022.II – 820.2 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий даатгалын зүйлийг 1.7 тэрбум төгрөгөөр буюу 482.5 дахин бага үнэлгээгээр даатгасан/


МОНГОЛ УЛСАД ТОХИРОХ УЛАМЖЛАЛТ БУС САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ

Энэхүү судалгааны ажлын хоёрдугаар бүлэгт олон улсад даатгалын эрсдэлийг шилжүүлэхэд түгээмэл ашигладаг уламжлалт бус санхүүгийн хэрэгслүүдийн талаар судалсан. Тэдгээр 5 уламжлалт бус санхүүгийн хэрэгслээс давхар даатгалын sidecar болон салбарын хохирлын баталгаа гэсэн 2 хэрэгслийг Монгол Улсад тохиромжтой гэж үзэж байна.

Зураг. Давхар даатгалын sidecar зураглал /Монгол Улсад ашиглаж болох загвар/



Зураг. Салбарын хохирлын баталгааны зураглал /Монгол Улсад ашиглаж болох загвар/



Монгол Улсад даатгалын үйл ажиллагаа явуулдаг 15 ердийн даатгалын компани болон урт хугацааны даатгалын компани болох “Нэйшнл лайф” ХХК нь нийлүүлэх хөрөнгийн босго дүн болон эрсдэлийн дээд хэмжээг урьдчилан тогтоож, гэрээ байгуулна.

Гэрээнд нэг удаагийн салбарын хохирлын баталгаа эсвэл цогц салбарын хохирлын баталгаа эсэхийг гэрээнд нарийвчлан тодорхойлно.

Нэг удаагийн салбарын хохирлын баталгаа – Нэг үйл явдлын

салбарын хохирол – эрсдэл тус бүр дээр дээд хэмжээг тогтоосон байдаг /жишээ нь: гал түймэр, газар хөдлөлт гэх мэт/

Цогц салбарын хохирлын баталгаа – Салбарын нийт хохирлын дээд хэмжээг тогтоодог. /жишээ нь: салбарын нийт хохирол 100 тэрбум төгрөг гэх мэт/

Эрсдэлийн дээд хэмжээг давсан тохиолдолд салбарын хохирлын баталгаанаас нөхөн төлбөр олгоно.

ДҮГНЭЛТ

Ерөнхийд нь дүгнэхэд, даатгалын болон хөрөнгийн зах зээл нь нягт уялдаа холбоотойгоор хамтран ажиллаж, зэрэгцэн хөгжсөнөөр улс орны санхүүгийн зах зээлд томоохон эерэг өөрчлөлт, нөлөөллийг авч ирдэг гэж хэлж болно.

Улс орнуудын даатгалын эрсдэл шилжүүлэх уламжлалт бус санхүүгийн хэрэгслийг судлахад даатгалын эрсдэлд суурилсан үнэт цаас, гамшгийн бонд, давхар даатгалын sidecar нь нийтлэг байв. Сүүлийн жилүүдэд олон улс дахь даатгалын үйд ажиллагаа эрхэлдэг байгууллагууд даатгалын эрсдэлээ уламжлалт бус санхүүгийн хэрэгслийг ашиглан, ихэнх тохиолдолд хөрөнгийн зах зээлд гаргаж байна. Судалсан уламжлалт бус хэрэгслүүд нь ихэвчлэн гамшгийн нөхцөл байдлын үед, олон давтамжтай болдог эрсдэл зэрэгт ашиглагддаг байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Швейцарын Холбооны Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Америкийн Нэгдсэн Улсын давхар даатгалын эрсдэлийг хэрхэн зохицуулж буйг судлахад БНХАУ нь хамгийн нарийн зохицуулалттай буюу бүрдүүлэх баримт бичиг, зохицуулагч байгууллагын үүрэг, давхар даатгалын компанийн баримтлах зарчим зэргийг тодорхойлсон байлаа. АНУ-ын зохицуулалт нь муж тус бүрээс хамааран харилцан адилгүй байсан бол Швейцар болон Герман улсад уламжлалт бус

хэрэгслийг зохицуулдаг тусгайлсан зохицуулалт байгаагүй болно.

АНУ-ын тухайд тухайн улсын даатгалын компаниуд нь өндөр татварын улмаас цаасан дээрх тусгай зориулалтын компани байгуулахдаа татваргүй буюу оффшор бүсэд байгуулах тохиолдол олон байна. Иймд тус улсын татварын шинэчилсэн зохицуулалтаар татвараас чөлөөлөх /аж ахуйн нэгжийн албан татвар болон хувь хүний орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх/ тогтолцоог бий болгосон.

Монгол Улсын тухайд эрсдэл шилжүүлэх уламжлалт бус санхүүгийн хэрэгсэл нь хараахан нэвтрээгүй байгаа ч Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “Даатгагч нь даатгалын эрсдэлийг шилжүүлэх уламжлалт бус санхүүгийн хэрэгслийг ашиглан даатгалын эрсдэлийг хөрөнгийн зах зээлд гаргаж болно” гэж тусгаж өгснөөр даатгалын компаниуд хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох, эрсдэлээ тархаан байршуулах боломжтой болсон.

Иймд даатгагчдыг хамтран ажиллах буюу хамтын даатгалыг хөгжүүлэх хүрээнд холбогдох даатгалын компаниудын хамтын ажиллагааг дэмжих, даатгалын эрсдэл шилжүүлэх уламжлалт бус санхүүгийн хэрэгслийн талаар мэдээлэл солилцох, боловсрол олгох зэрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

Цуврал №17

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд



МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГ ГЭЖ ЮУ ВЭ?

Мөнгө угаах гэдэг нь: Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг хэлнэ.

Өөрөөр хэлбэл: Гэмт хэрэг үйлдэх замаар олсон "бохир" мөнгийг "цэвэр" буюу хууль ёсны болгохыг мөнгө угаах гэмт хэрэг гэнэ.



Мөнгө угаах гэмт хэрэг үйлдэж буй түгээмэл арга:



1 Мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ашиглах



2 Криптовалютаар шилжүүлэх



3 Хандив, тусламж өгөх



4 Хавала, хунди зэрэг хууль бус сүлжээ ашиглах



5 Хууль бусаар улс дамжиж бараа тээвэрлэх



6 Залилан, хулгай дээрэм хийх



7 Хувийн мэдээлэл хулгайлж мөнгө нэхэх



8 Хууль бусаар үнэт металл, үнэт чулуу олборлох



9 Хандив, тусламжийн мөнгийг зүй бусаар ашиглах

Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргүүд:



ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР



**САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

Цуврал №17

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ҮЕ ШАТ



1. БАЙРШУУЛАХ

Хууль бусаар олсон мөнгөө санхүүгийн систем рүү нэвтрүүлэх



2. НУУН ДАЛДЛАХ

Бохир аргаар олсон мөнгийг нуун далдлах



3. БУЦААН ТӨВЛӨРҮҮЛЭХ

Тансаг хэрэглээ, хөрөнгө оруулалт руу шилжүүлэх

БИД ЯАГААД МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААР МЭДЭХ ЁСТОЙ ВЭ?

"Мөнгө угаах гэмт хэрэг"–ийн сөрөг нөлөө нь юу юм бол доо...



- Эдийн засаг, нийгэм, улс төрийн нөхцөл байдалд **сөргөөр нөлөөлнө**;
- Санхүүгийн системийн **тогтвортой байдлыг алдагдуулна**;
- **Хямрал** бий болно;
- Олон улсын түвшинд дотоодын банк, санхүүгийн байгууллагын **нэр хүнд унана**;
- Банк, санхүүгийн байгууллагаар дамжуулан хийгдэж буй **гадаад гүйлгээг саатуулан, шалгана. Харилцахаас татгалзана**;
- **Хээл хахууль, авлига** нэмэгдэнэ;
- **Шударга, чөлөөт өрсөлдөөний зарчим алдагдана**;
- Улсын төсвийн орлого буурч, **шударгаар татвараа төлж буй иргэд хохирно**.



Өмнөх цувралуудтай энэхүү холбоосоор орж танилцаарай



ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

ҮНЭТ ЭДЛЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Үнэт эдлэл гэдэг нь: Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн гоёл чимэглэлийн зүйлсийг (бөгж, хүзүүний зүүлт, ээмэг, бугуйвч гэх мэт) хэлнэ.

Эрдэнэсийн сангийн тухай хуульд зааснаар:

"үнэт металл" – алт, мөнгө, платина болон түүний бүлэгт багтдаг палладий, иридий, родий, рутений, осмийг;



"үнэт чулуу" – доржпалам, бадмаараг, маргад эрдэнэ, индранил, сувдыг;



Үнэт эдлэлээ зөв сонгоход **карат /сорьц/** чухал үүрэгтэй байдаг

Жишээ болгон алтыг авч үзвэл **карат гэдэг нь** үнэт эдлэлийг хийхэд хичнээн хэмжээний алт орсныг хэмждэг нэгж юм.

Карат нь 2 утгыг агуулдаг



Үнэт металлээр хийсэн эдлэл дээрх карат /к/-ын тэмдэглэгээ нь сорьц



Үнэт чулуун дээрх карат /сг/-ын тэмдэглэгээ нь түүний жин

24k– 99.9% сорьцтой буюу цэвэр алт;
18k– 75% алт, 25% бусад металл гэх мэт.

1ct– 200мг;
0.5ct– 100мг-тай тэнцэх гэх мэт

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

ҮНЭТ ЭДЛЭЛ ХУДАЛДАН АВАХДАА АНХААРАХ ЗӨВЛӨМЖ

Үйлдвэрлэгчийн барааны тэмдэг, улсын сорьцын баталгааг шалгах

дээрх тэмдгүүд нь мэдэгдэхгүй, балархай, цифрүүдийн шрифтийн хэмжээ харилцан адилгүй зэрэг эдлэлийг хийсэн металл нь үнэт металл биш байх магадлалтай.



Үнэт эдлэлийг таних хамгийн энгийн арга нь үнэ юм

үнэт чулуун шигтгээтэй алт, мөнгөн эдлэл нь их өндөр үнэтэй байх бөгөөд хямд байвал үнэт эдлэл биш гэж ойлгож болно.




Үнэт эдлэлийн жин, чулуун шигтгээ зэргийг шалгуулах

эдлэлийн нэр, сорьц, жин, чулуун шигтгээний нэр, байгалийн, таримал, дуураймал аль нь болох, карат зэргийг бичүүлсэн гэрчилгээг авах.



Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг зохицуулах журмыг баталсан.



Та дараах QR кодыг уншуулж худалдан авалт хийх гэж буй газар тань тусгай зөвшөөрөлтэй эсэхийг шалгах боломжтой.



Тусгай зөвшөөрөлтэй гэдэг нь **баталгаатай гэсэн үг биш** бөгөөд та хариуцлагаа өөрөө хүлээх тул сайтар нягталж сонголтоо хийгээрэй.



ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

СТАТИСТИКИЙН ТООЦООЛЛЫН СУУРЬ ОЙЛГОЛТУУД ХИЧЭЭЛ №9




ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ГАЗРЫН ДАРГА В.ЭНХБААТАР

“ИНДЕКС” ТЭНЦҮҮ ЖИГНЭСЭН ИНДЕКС

Тэнцүү жигнэсэн индекс гэдэг нь индексэд багтсан компанийн үнэт цааснуудад тэнцүү хэмжээгээр хөрөнгө оруулсан индекс бөгөөд мэргэжлийн хүрээнд ‘жигнээгүй индекс’ ч гэж мөн нэрлэдэг. Ийм индексийн хувьд зах зээлийн өндөр үнэлгээтэй том компаниуд жижиг компанитай адилхан ач холбогдолтой бөгөөд индексийн үнэлгээнд багцын бүрэлдэхүүнд байх компаниудын үнэт цаасны арилжаа ижил нөлөө үзүүлнэ.

Портфолио, индекс, мөн индекс сангийн арилжааны гүйцэтгэлийг тооцоолоходоо индексийн бүрэлдэхүүнд багтах компаниудын үнэт цааснуудад адил жин оноож, адил хөрөнгө оруулалт хийдэг.



Тэнцүү жигнэсэн индекс нь хөрөнгийн индекс, портфолиод байх үнэт цааснуудыг зах зээлийн үнэлгээгээр нь жигнэж тооцоолдог аргачлалаас ялгаатай. Зах зээлийн үнэлгээгээр жигнэсэн индексэд олон ширхэг хувьцаатай, нэгж хувьцаа нь өндөр үнэтэй компаниудын үнэлгээ тухайн индексийн үнэлгээнд илүү жинтэй нөлөөлнө. Харин тэнцүү жигнэсэн индексэд компаниудын том жижгээс үл хамааран бүгд адил жин оноож индексийг тооцоолдог бөгөөд хувьцаа нь үнэтэй, том компани байхаас үл хамааран индексийн үнэлгээнд багцад байгаа бүх компаниуд ижил нөлөө үзүүлдэг.

Тэнцүү жигнэсэн индекс үнэлгээ = (үнэт цаас 1 х жин)

+ (үнэт цаас 2 х жин) + (үнэт цаас 3 х жин) + (үнэт цаас 4 х жин)

Индексэд багтах компаниуд буюу үнэт цаасны тоог n –р илэрхийлбэл багцын бүх үнэт цаасны жинг адил оноох учир нэг үнэт цаасны жин $1/n$ байна, харин үнэт цаасны үнийг i –аар илэрхийлбэл дээрх тэнцлийг дараах байдлаар томъёолно.

$$\text{Тэнцүү жигнэсэн индекс үнэлгээ} = \sum_{i=1}^n i x \frac{1}{n};$$

Тэнцүү жигнэсэн индексийн бүрэлдэхүүнд багтах бүх компаниудын үнэт цаасны арилжааны дүн индексийн үнэлгээнд адил нөлөөлнө. Иймд зах зээлийн үнэлгээгээр жигнэсэн индексстэй харьцуулахад илүү олон тулгууртай, эрсдэл багатайд тооцогдоно.

Хөрөнгө/үнэт цаас	Үнэ	Жин %	Үнэлгээ
A	120	25%	30
B	85	25%	21.25
B	130	25%	32.5
Г	42	25%	10.5
		100%	
Тэнцүү жигнэсэн индекс			94.25

Шинэ индекс тооцоходоо өмнөх индексэд байх үнэт цаас бүрийн өгөөжийн арифметик дундаж, эсвэл индексийн үнэлгээний өөрчлөлтийн хувийг тооцоолж, өмнөх индексийн утга дээр нэмж тооцоолно.

Шинэ индекс = Өмнөх (тэнцүү жигнэсэн) индекс + (1 – индексийн үнэлгээ ▲ %)

Дээрх индексийн үнэлгээ тодорхой хугацааны дараа 3% нэмэгдсэн гэж үзвэл:

$$\text{Шинэ индекс} = 94.25 + (1 - 0.03) = 95.22$$

Тэнцүү жигнэсэн индекс нь урт хугацааны хөрөнгө оруулалтад бусад индексээс илүү өгөөжтэй, индексэд багтсан том компанийн арилжааны гүйцэтгэлээс хамаардаггүй багцад байх бүх үнэт цаасны үнээр индексийн үнэ тогтдог учир илүү олон тулгууртай (diversified), эрсдэл бага, хөөрөгдсөн хэт өндөр үнэтэй үнэт цаасны нөлөө бага гэх мэт давуу талуудтай. Харин бүх үнэт цааснуудад адил хэмжээтэй хөрөнгө оруулдаг тул эх үүсвэр өндөр шаарддаг, хямралын үед эмзэг, хувьцааны үнэ буурсан арилжааны гүйцэтгэл тааруу компаниудын үнэт цаас бусадтайгаа адил жин эзэлдэг гэх мэт сул талуудтай.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ШҮГЭЛ ҮЛЭЭХ НЬ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

Түүхэн дэх орчин үеийн компаниудтай холбогдох томоохон дуулиан үүсгэсэн асуудал нь ихэвчлэн шүгэл үлээгчээс (хэн нэгэн нь асуудлыг олж харан ямар нэг юм хэлэх хэрэгтэй гэх бодлоос) үүдэлтэй байдаг. Иймд компаниудын төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ болон гүйцэтгэх удирдлагууд эдгээр хүмүүсийг сонсож, мэдээлэлтэй нь зөв харьцаж, аюулгүй байдлыг нь хэрхэн хангах вэ гэдэг асуудал үүсэж байна.

Шүгэл үлээгчид хаа сайгүй байдаг.

2022 оны 10 дугаар сард болсон Ирланд улсын 200 бизнесүүдийн цугларалтын үеэр 4 компани тутмын 1 нь сүүлийн гурван жилийн хугацаанд хууль бус үйлдлийн талаарх мэдээллийг хүлээн авсан нь тогтоогдсон бол оролцогчдын 85.0 хувь нь Ирландад цагаан захтны гэмт хэрэгтэй хүчтэй тэмцдэггүй гэж хариулжээ.

Ирланд нь хэдийгээр жижиг арал хэдий ч Европын санхүүгийн чухал төв хэвээр байгаа бөгөөд сүүлийн үеийн статистик, тоон мэдээллээс үзэхэд нөхцөл байдал тийм ч таатай биш байна. Тэд шүгэл үлээх ажиллагааны ач холбогдлын чухлыг онцолж байгаа боловч шүгэл үлээх ажиллагааг дэмждэггүй дотоод орчныг бүрдүүлэх нь эсрэгээрээ маш амар байх талаар ярилцжээ.

Шүгэл үлээх ажиллагаанд юу хамаарах вэ?

Шүгэл үлээгч гэдэг нь компанийн аливаа хууль бус үйлдэл, зөрчлийн талаарх мэдээллийг шийдвэр гаргагч албан тушаалтнуудад мэдээлдэг этгээд бөгөөд ихэвчлэн ажлаас гарсан хуучин ажилтнууд байдаг. Шүгэл үлээх ажиллагаа нь дараах хэлбэртэй байж болно:

- Дотоод буюу шүгэл үлээгч нь компанийн ахлах ажилтнуудад мэдээлэл өгдөг;
- Гадаад буюу байгууллага нь дотооддоо асуудлыг зохих ёсоор шийдвэрлэнэ гэдэгт итгэдэггүйгээс болж тухайн шүгэл үлээгч эрх баригчид эсвэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээдэг.

Компанийн ТУЗ нь дотоод шүгэл үлээх ажиллагааг илүү анхаарч үздэг боловч гадаад шүгэл үлээлт нь компанид нэр хүндийн эрсдэл үүсгэдэг тул ТУЗ үүнд гол анхаарлаа хандуулах шаардлагатай байдаг.

Шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчин.

Эрх зүйн системийн онцлогоос хамаарч улс орнууд харилцан адилгүй зохицуулсан ч ихэнх улсууд тусгайлсан хуультай байдаг. Тус хууль нь ерөнхийдөө шүгэл үлээгчийн мэдээллийг задруулах, аливаа хууль бус үр дагавраас хамгаалах асуудлыг зохицуулдаг байна. АНУ нь Их Британи, Европын Холбооны улсуудын нэгэн адил шүгэл үлээгчийн талаар өргөн хүрээг хамарсан хууль тогтоомжтой ба энэ нь хэн нэгнээс ямар нэг нууц мэдээлэл авах тохиолдолд гүйцэтгэх ТУЗ-ийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж өгдөг. Гэхдээ ТУЗ зөвхөн хуульд заасны дагуу ажиллах нь хангалтгүй ба тэрээр компанийн ажилтан болон бизнесээ хамгаалах тасралтгүй үйл явцыг хангахын тулд ямагт бүхний урд алхах шаардлагатай байдаг.

ТУЗ яагаад шүгэл үлээгчид санаа тавих ёстой вэ?

ТУЗ-ийн үндсэн үүрэг бол компанийн үйл ажиллагааг хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолд нийцүүлж, тасралтгүй, амжилттай явуулах явдал юм. Шүгэл үлээх нь амжилтад саад учруулж болзошгүй эрсдэлүүдийг онцлон тодорхойлдог.

Компанийн ТУЗ дараах шалтгааны улмаас шүгэл үлээгчид анхаарлаа хандуулах шаардлагатай:

- Тэдний мэдээлэл нь асуудал цаашид улам эмх замбараагүй байдалд хүрэхээс урьдчилан сэргийлж, түүнээс үүдэн гарах хүндхэн асуудлыг зогсоож чадна;
- Шүгэл үлээгчийн мэдээллийг хүлээн авах нь байгууллага дотор шударга, эерэг соёлыг бий болгоно.

Шүгэл үлээгчдийн өмнө ТУЗ-ийн хүлээх хариуцлага.

Шүгэл үлээх болон ТУЗ-ийн үйл ажиллагаа нь компанийн зүгээс

баримтлах бодлогод тусгагдсан байдаг. Шүгэл үлээгчийн бодлого, тогтолцоог бий болгосноор тухайн байгууллага дагаж, мөрдөж болохуйц замын зурагтай болох юм. Хэрэв бодлого байхгүй бол ажилтнууд хэнтэй ярилцаж, хууль бус зүйлийг хаана мэдээлэх нь тодорхойгүй, нөгөө талаас тухайн мэдээллийн дагуу удирдлагууд цаашаа юу хийхээ мэдэхгүй, эргэлзээтэй байдалд орно.

ТУЗ нь дараах үүрэгтэй:

- Шүгэл үлээгчийн баримтлах бодлогыг боловсруулж, мэдээлэл өгөх, мэдээллийн улмаас үүсэж болзошгүй үр дагавар, аюулгүй байдалдаа санаа зовохгүйгээр шүгэл үлээх үе шат хэрэгжүүлэх үйл явцыг тодорхой болгох;
- Шүгэл үлээх ажиллагааг бүх ажилтнууд мэддэг, хэрэгжүүлэх боломжоор хангах /Хэзээ ч ашигладаггүй гарын авлага болгож болохгүй/;

- Дээрээс доош нээлттэй, шударга соёлыг төлөвшүүлэх /Хувьцаа эзэмшигчид, удирдах албан тушаалтнуудад компани үнэнч шударга байдлыг дэмждэг гэдгийг ТУЗ ойлгуулах хэрэгтэй/;
- Мэдээлэл бүрийг сонсох.

Товчдоо, ТУЗ шүгэл үлээгчийн бодлого, тогтолцоог бий болгох, компани дотроо хямарснаар хохирол амсах нь гадаад шүгэл үлээхтэй холбоотой хямралтай тулгарснаас илүү хялбар гэдийг ойлгох нь чухал.

Ирланд улсын хамгийн сүүлийн үеийн тоо баримтаас үзэхэд, шүгэл үлээх нь бидний бодож байснаас илүү түгээмэл хэрэгждэг аж.

Эх сурвалж: Corporate governance institute



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“BINANCE” ӨРСӨЛДӨГЧ БИРЖЭЭ ХУДАЛДАЖ АВАХААС ТАТГАЛЗАВ.



Дэлхийн хамгийн том криптовалютын бирж болох “Binance” крипто зах зээл дахин уналтад орох магадлалтай гэсэн болгоомжлолын улмаас “FTX” биржийг худалдан авах тохиролцоонд хүрч байсан. Ингэхдээ 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр “Binance”-ийн ерөнхий захирал Чанпэн Жао нь “заавал өрсөлдөгчөө худалдан авах ёстой биш, худалдан авахаас ямар ч үед татгалзаж болно” гэсэн гэрээг байгуулсан.

Худалдан авалтын хэмжээг тодорхойлох боломжгүй байсан ба хувийн эзэмшил бүхий “FTX” бирж өмнө нь 32 тэрбум доллар гэж үнэлэгдэж байсан.


Binance нь “FTX” биржийн хэрэглэгчдийг дэмжиж, хөрвөх чадвараар хангахыг хүссэн боловч тус компанид иж бүрэн үнэлгээ хийсний дараа бид худалдан авахгүй байхаар шийдсэн” гэж мэдээлсэн байна. Тус шийдвэр гаргалтад хэрэглэгчийн мөнгийг зүй бусаар ашигласан тухай сүүлийн үеийн мэдээллүүд, АНУ-ын Үнэт цаас, биржийн хороо /SEC/ явуулж буй мөрдөн шалгах ажиллагаа мөн нөлөөлсөн байна.

Эх сурвалж: www.nytimes.mn

АНУ-ЫН ХОЛБООНЫ НӨӨЦИЙН САН БОДЛОГЫН ХҮҮГЭЭ ДАХИН ӨСГӨВ.

2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр АНУ-ын Холбооны нөөцийн сан бодлогын хүүгээ 4 дэх удаагаа дараалан 0.75 пунктээр өсгөж байгаагаа мэдэгдлээ. Ингэснээр 3.75–4.00 хувьд хүрсэн нь 2008 оны 01 дүгээр сараас хойших хамгийн өндөр түвшинд хүрч байна.

Төв банкны үүрэг гүйцэтгэгч “Инфляцын түвшнийг 2.0 хувь хүртэл бууруулахын тулд бодлогын хүүг цаашид дахин нэмэгдүүлнэ” гэж мэдэгдсэн. Тус улсын инфляцын түвшин 2022 оны 10 дугаар сарын байдлаар 7.7 хувьд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 1.5 пунктээр өссөн. 2022 оны 6 дугаар сард АНУ-ын инфляцын түвшин 9.1 хувьд хүрч, сүүлийн 40 жилийн хамгийн дээд түвшинд хүрч байсан бол одоо үүнээс 1.4 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.



Эх сурвалж: www.cnbcmn

АНГЛИЙН ТӨВ БАНК БОДЛОГЫН ХҮҮГЭЭ ДАХИН ӨСГӨВ.



Английн Төв банк бодлогын хүүгээ 0.75 пунктээр өсгөж, 3.0 хувьд хүрлээ /0.25, 0.5, 0.75 пунктээр өсгөхөөр санал авсан/. Бодлогын хүүг 3.0 хувьд хүргэсэн нь зах зээлийн хүлээлттэй нийцнэ гэж үзсэн байна. Ингэснээр бодлогын хүүг 8 дахь удаагаа дараалан өслөө.

Төв банкны ерөнхийлөгч Эндрю Бэйли “Инфляц цаашид ч өсөж, эрсдэлүүд тулгарсаар байх тул бид бодлогын хүүгээ өсгөж байна” хэмээн тайлбар өгсөн байна.

Төв банк энэхүү шийдвэрийг гаргаснаар 1989 оноос хойш мөнгөний бодлогын хүрээнд бодлогын хүүгээ анх удаагаа өндөр хувиар өсгөсөн байна. Тус улсад инфляц түүхэн дээд түвшинд хүрэх магадлалтай бөгөөд хэрэглээний үнийн индекс /ХҮИ/ 2022 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.1 хувиар өссөн байдалтай байна.

Эх сурвалж: www.bloomberg.mn

ЕВРО БҮСИЙН ИНФЛЯЦЫН ТҮВШИН СҮҮЛИЙН 25 ЖИЛИЙН ДЭЭД ХЭМЖЭЭНД ХҮРЧЭЭ.



Евро бүсийн инфляц 2022 оны 10 дугаар сард дээд үзүүлэлтийг эвдэж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.7 хувиар өссөн байдалтай байна.

Европын холбооны Статистикийн газар /Eurostat/-ын урьдчилсан мэдээллээр, инфляц 9 дүгээр сард 9.9 хувиас хурдацтай өсөж, инфляцын дээд түвшнийг шинэчилжээ.

Ийнхүү Евро бүсийн инфляцын түвшин 2022 оны 10 дугаар сард сүүлийн 25 жилийн дээд түвшинд хүрсэн ба одоогийн инфляцын түвшин нь Европын Төв банкны зорилтот 2.0 хувиас 5 дахин их байна.

Улсуудын инфляцын түвшин /ихээс бага руу жагсаасан/: Эстони 22.2 хувь, Литва 22.0 хувь, Латви 21.8 хувь, Нидерланд 16.8 хувь, Словак 14.5 хувь, Бельги 13.1 хувь, Итали 12.8 хувь, Герман 11.6 хувь, Австри 11.5 хувь, Португал 10.6 хувь, Словени 10.3 хувь, Грек 9.8 хувь, Ирланд 9.6 хувь, Люксембург 8.8 хувь, Кипр дэх Грекийн нийгэмлэгт 8.6 хувь, Финланд 8.3 хувь, Мальта 7.5 хувь, Испани 7.3 хувь, Франц 7.1 хувь

Эх сурвалж: www.cnbc.mn




ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр


S&P 500 /^GSPC/

3,963.94 -62.18 (-1.54%)




Nikkei 225 /^N225/

28,027.84 -134.99 (-0.48%)




FTSE 100 /^FTSE/

7,536.05 +62.11 (+0.83%)



NASDAQ Composite (^IXIC)

11,049.50 -176.86 (-1.58%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com





© САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia